

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ

БАТЛАВ

Я.САМБУУНЯМ

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БАРИГДАЖ БАЙГАА ЗАРИМ  
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫН ТӨСӨВТ ӨРТӨГ, НЭМЭГДЭЛ ЗАРДАЛД  
ТООЦООЛОЛ ХИЙХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 12 дугаар  
сарын 11.-ны өдөр

Дугаар УАГ-АО/2024-39

Улаанбаатар хот

**АЖЛЫН ЗОРИЛГО:** “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийх гүйцэтгэлийн, “Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах” нийцлийн аудитын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа зарим барилга байгууламжийн төсөвт өртөг нь Монгол Улсын хууль тогтоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

#### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

**Эхлэх хугацаа:** 2025 оны 01 дүгээр сарын 15 -ны өдөр

**Дуусах хугацаа:** 2025 оны 11 дүгээр сарын 01 -ний өдөр

**Байршил:** Улсын хэмжээнд

#### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоолд үндэслэн хийх “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийх гүйцэтгэлийн, “Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт аудитын дүгнэлт гаргах” нийцлийн аудитад Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу мэргэжлийн тусгай мэдлэг, ур чадвар бүхий этгээдийг шинжээчээр татан оролцуулна.

#### ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь аудитын багтай хамтран улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа, төсөвт өртгийн нэмэгдэл зардалд дүгнэлт гаргах жагсаалтад багтсан барилга байгууламжийн ажлын төсөвт өртөг, нэмэгдэл зардалд давтан тооцоолол, дүн шинжилгээ хийх ажлыг хэрэгжүүлнэ.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь багцад тусгасан ажлын тоо, төсөл, арга хэмжээ бүрээр дараах ажилбаруудыг гүйцэтгэнэ. Үүнд:

д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Барилга, байгууламжийн төсвийг баталсан зураг төслийн дагуу холбогдох хууль тогоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиосон эсэх, төсөвт өртгийг нэмэгдүүлж магадлалаар баталгаажуулсан нь үндэслэлтэй эсэхэд дүн шинжилгээ хийх;	Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйл “Барилга байгууламжид тавих шаардлага”, 24 дүгээр зүйл “Барилга байгууламжийн төсөв”, 25 дугаар зүйл “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх”, 39 дүгээр зүйл “Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх эксперт”, “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм” /БНБД 81-94- 12/, “Барилгын төсөв зохиох дүрэм” /БНБД 81-95-12*/2020/	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан зарим барилга, байгууламжийн зураг төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, Монгол Улсын хууль тогоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандарт шаардлагад нийцсэн эсэхэд дүгнэлт гаргахад оршино.	<input checked="" type="checkbox"/> Төсвийг холбогдох зөвшөөрөл бүхий байгууллага, хуулийн этгээд гүйцэтгэсэн байх; <input checked="" type="checkbox"/> Магадлал хийгдсэн зураг төслийг үндэслэсэн байх, <input checked="" type="checkbox"/> Төсвийг хүчин төгөлдөр мөрдэж байгаа хууль тогоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиосон байх,
2	Дүн шинжилгээ хийх ажлын явцад зураг төсөл, ажлын тоо хэмжээ, барилгын материалын орц, үнэ, хэмжээ, нэр төрөлд зөрүү илэрсэн тохиолдолд төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг тооцоолж гаргах;	Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйл “Барилга байгууламжийн төсөв”, “Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм /БНБД 81-94-12/, “Барилгын төсөв зохиох дүрэм” /БНБД 81-95-12*/2020/, холбогдох бусад хууль, журам, заавар, норм, дүрэм.		<input checked="" type="checkbox"/> Барилга, байгууламжид ашигласан барилгын материалын орц, тоо хэмжээ, нэр төрөл, чанар нь зураг төсөл, холбогдох норм, дүрэм, стандартад нийцэж байх. <input checked="" type="checkbox"/> Ажлын тоо хэмжээ, төсөв нь баталгаажсан зураг төсөл, холбогдох норм дүрэмд нийцэж байх. <input checked="" type="checkbox"/> Магадалшгүй ажлын зардал, бусад зардлыг бүрэн, үнэн зөв тусгасан байх;

### Гэрээт ажилд тавигдах шаардлага, хэмжээ, формат

- Шинжээчийн ажлын тайлан нь төсвийн тооцооллыг эрх бүхий төсвийн программаар гүйцэтгэсэн хавсралтуудтай байна.
- Тайлан, тайлангийн хавсралтыг аудитын багтай зөвшилцөн нэгдсэн загварын дагуу бэлтгэж болно.

- Шинжээчийн дүгнэлт гаргах үндэслэл болгосон нотлох баримтын шаардлага хангасан баримт бичиг, тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Тооцоолол дүгнэлт гаргахад ашигласан хууль, стандарт, норм, дүрэм, шалгуур болгосон мэдээллийн эх үүсвэрийг тодорхой тусгасан байна.

## ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шинжээч нь ажлын даалгаварт заасан ажилбаруудыг төсөл, арга хэмжээ бүрээр, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, барилга, байгууламжийн төсөвт өртөг нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, норматив, стандартаар тавигдах бусад шаардлагуутай нийцсэн эсэхийг хянан үзэж, гарсан үр дүнг тусгасан тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн ажил гүйцэтгэх явцад барилга байгууламжийн зураг төсөл, нэмэлт ажлын төсөвт илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгааныг тайланд тусгана.

Шинжээчийн тайлан, хавсралтаар гаргасан тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

## ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээч нь баг, хуулийн этгээд, иргэн байж болно.

Хуулийн этгээд нь дүгнэлт гаргахаар санал ирүүлсэн барилга байгууламжийн чиглэлээр зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий байх ба үндсэн ажилтны бүрэлдэхүүнд тэргүүлэх төсөвчин болон тухайн чиглэлийн инженерүүд байна.

Шинжээчийн ажлыг багаар гүйцэтгэх тохиолдолд багийн ахлагч нь тэргүүлэх төсөвчин, багийн гишүүд мэргэшсэн төсөвчин байна. Баг нь 5 гишүүнтэй, барилгын инженер-1, цахилгааны инженер-1, халаалт агаар сэлгэлтийн инженер-1, ус хангамж ариутгах татуургын инженер-1, холбоо дохиоллын инженер-1, багийн ахлагч мэргэжлээрээ 5-аас дээш жил, гишүүд 3-аас дээш жилийн ажлын туршлагатай байна.

Иргэн нь барилга, цахилгаан, авто зам, халаалт, агаар сэлгэлт, ус хангамж, ариутгах татуурга, холбооны аль нэг чиглэлийн инженер бөгөөд тэргүүлэх төсөвчин, мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан туршлагатай байна.

Шинжээч нь аудитын явцад олж авсан төрийн болон албаны нууц, байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

### Бүрдүүлэх материал:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн албан бичиг, хүсэлт, хуулийн этгээдийн гэрчилгээ, иргэний үнэмлэх, анкет, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, үнэмлэх, сертификатын хуулбар;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө, танилцуулга), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);
- Энэхүү ажлын даалгаврын 5-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлнэ.

## **ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.